

хаагчид хуулийг буруу хэрэглэх, үүний улмаас иргэд хохирох, алба хаагчийн өөрийнх нь эрх ашиг хөндөгдөх явдал олонтоо гарч байв.

Иймд эдгээр эрх зүйн болон бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах, ШШГБ-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, шинээр дүрэм, журам боловсруулан тэдгээрийг Монгол Улсын хууль, олон улсын стандартад нийцүүлэн системчлэх нь байгууллага, алба хаагчын үйл ажиллагааг улам төгөлдөршүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

*Г. Тамир -Хууль сахиулахын удирдлагын академийн
Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн
профессор, хурандаа*

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ БА ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ялангуяа хорих байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангахад ямар үүрэгтэй оролцдог, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд тулгамдаж буй гол асуудал нь юу болох, түүнийг хэрхэн шийдвэрлэх тухай өгүүлсэн.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, зорилго, зарчим, эрүүгийн хариуцлага, хорих ял, дэглэм, нөхцөл

Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлд "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журмыг хангах нь хангах нь төрийн үүрэг мөн" гэж тунхагласан бол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, **хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд**, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ" гэжээ. Мөн Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "Хууль тогтоох, **гүйцэтгэх**, шүүх **эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд**, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй", 7 дугаар зүйлийн 7.1-д " Зэвсэгт хүчин **бусад** цэрэг'-ийг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг

үүрэгтэй байгууллагад хамааруулсан¹ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад холбогдох заалт мөн.

Тус байгууллага нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн^{1 2} хэсэг болох "дотоод аюулгүй байдал", "Хүний аюулгүй байдал"-ыг хангахад; тэдгээрийн дотор хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах, хүнийг гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалахад тодорхой үүрэг гүйцэтгэх ба хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүргүүд нь дээрх зорилтыг хангахад чиглэгддэг.

Тэгэхээр хорих байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа нь үндэсний аюулгүй байдал хангах үйл явцад нөлөөлөх, өөрөөр хэлбэл хуулиар хүлээсэн чиг үүргээ ямар хэмжээнд гүйцэтгэнэ, төдий хэмжээгээр үндэсний аюулгүй байдалд гүйцэтгэх өөрийн үүргээ биелүүлнэ.

Хорих байгууллага нь аюулгүй байдлыг хангах тогтолцоонд тодорхой байр суурь эзэлдэг болохыг дээрх эрх зүйн эх сурвалжуудын агуулгаас харж болно. Гэвч үндэсний аюулгүй байдлыг хангахад хорих байгууллагын үүрэг, оролцоо нь юу вэ? гэсэн асуулт зүй ёсоор урган гарч байна. Энэ тухай хууль зүйн тодорхойлолт, албан ёсны байр суурь, ойлголт хараахан бий болоогүй байна. Байгууллагын хувьд гүйцэтгэх ёстой хуулиар тогтоосон олон чиг үүрэг бий. Гэвч эдгээрийн аль нь үндэсний аюулгүй байдлыг хангахад голлох үүрэгтэй вэ?, бид үндэсний аюулгүй байдлыг хангахад хэрхэн оролцдог вэ? гэдэгт хариулах шаардлага тулгарч байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хорих ялыг албадан эдлүүлж, эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чиглэсэн, төрийн өвөрмөц чиг үүрэг бол хорих ял эдлүүлэх ажиллагаа юм. Тус байгууллага нь энэхүү ажиллагааг голлон хэрэгжүүлэгч болохын хувьд үйл ажиллагаагаа эрүүгийн хариуцлагын зорилгод баримжаалах учиртай. Өөрөөр хэлбэл хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго нь эрүүгийн хариуцлагын зорилгоор тодорхойлогддог тул энэ зүй тогтолд нийцүүлэн үйл ажиллагаагаа зохион байгуулах ёстой.

Эндээс эрүүгийн хариуцлага, ялын зорилгын тухай асуудлыг авч үзэх шаардлага урган гарч байна. Эрүүгийн хууль тогтоомж нь гэмт

¹ <http://www.legalinfo.mn>

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд; Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал нь "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий зургаан бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар бодлогын хувьд томъёолсон байдаг.

хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хамгаалах агуулгатай ба энэ нь нийгмийн гишүүдийн нийтлэг эрх ашигт нийцдэг. Нийгмийн гишүүдийн энэхүү нийтлэг эрх ашиг сонирхлыг эрүүгийн хариуцлага /ял/-ын зорилготой уялдуулан ойлгож болно. Тэгэхээр хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, цаашилбал нийгмийн гишүүдийн нийтлэг эрх ашигт үйлчлэх агуулгатай болж байна. Эрүүгийн хариуцлагын зорилго, хорих ял эдлүүлэх ажиллагаа нь салшгүй холбоотой бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглүүлэгч нь эрүүгийн хариуцлагын зорилго байдаг бол уг зорилгыг хангах нэг чухал арга, хэрэгсэл нь хорих ял эдлүүлэх ажиллагаа юм. Нөгөө талаас хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хариуцлагын зорилгыг дангаараа бүрэн хангах боломжгүйг дурдах нь зүйтэй. Тухайлбал: эрүүгийн хариуцлага дахь **“иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах”** гэсэн зорилтыг хорих ял эдлүүлэх ажиллагаа дангаараа гүйцэтгэх боломжгүй.

Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу нь шүүхээр тогтоогдсон үеэс эхлэн ял шийтгэлгүйд тооцогдох хүртэл хугацаанд үргэлжилнэ. Эрүүгийн хариуцлагын зорилго нь: иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино¹.

1934 оны “БНМАУ-ын шүүх цаазын бичиг”. түүнээс хойш батлагдсан эрүүгийн хуулиудад ялын зорилгыг тусгайлан хуульчилж иржээ. Харин 2002 онд баталж өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуульд ялын зорилгыг тусгайлан хуульчлаагүй^{1 2}. Иймд эрүүгийн ялын болон хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгыг эрүүгийн хариуцлагын зорилготой уялдуулан авч үзвэл зохино.

Энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөө, үр дүнг эрүүгийн хариуцлагын зорилготой харьцуулан судлах шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангаж байна уу? гэсэн асуултыг бид өөрсөддөө тавих ёстой.

Энэ асуултад чанарын болон тооны талаас нь хариулж болно. Тооны талаас хорих ялын гүйцэтгэл өндөр, бараг 99-100 хувьтай байдаг. Хорих газраас оргосон, зайлсхийсэн ялтны тоог, нийт хорих ял эдлэгсэдийн тоонд харьцуулж энэ тоог гаргадаг. Гэтэл хорих газраас суллагдсан ялтны 40-50³

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, 45-р зүйл, 2002

² Г.Тамир, “онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” магистрын зэрэг горилсон судалгааны ажил, 2013 он

³ <http://mojha.gov.mn>

хувь нь дахин гэмт хэрэг үйлдэг ба энэ нь чанарыг илтгэх үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч хорих ялын үр нөлөө, үр дүнг чанарын талаас нь тооцдог, үнэлж дүгнэдэг механизм манайд байдаггүй тул уг асуудалд анхаарлаа хандуулах учиртай.

Хорих байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангахад дээр дурдсан чиг үүргийг гүйцэтгэхээс гадна өөрийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

1. Хорих байгууллагын ажилтан, албан хаагчдын аюулгүй байдал
2. Хорих байгууллагад хоригдогсдын аюулгүй байдал
3. Хорих байгууллагад албан ба хувийн шугамаар нэвтрэгсдийн аюулгүй байдал
4. Хорих байгууллагын нутаг дэвсгэр буюу орчны аюулгүй байдал
5. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах гэх мэт.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ялангуяа хорих байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн баялаг уламжлалтай.

Нийгмийн дэг журам, тогтоосон хэм хэмжээг зөрчсөн гэмт этгээдэд ял шийтгэх, тэр дундаа шорон гянданд хорьж цээрлүүлэх явдал Монголын анхны төрт улс Хүннүгийн үеэс эхлэн дараа дараагийн төрт улсуудад хэрэгждэг байсан тухай баримт түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэн байна¹. Гэхдээ өнөөгийн хорих ялыг дээрхтэй шууд адилтган үзэж болохгүй бөгөөд гэмт этгээдийг тодорхой хугацаагаар хорьж шийтгэдэг өнөөгийн практик 1926 онд батлагдсан эрүүгийн хуульд анх тусгалаа олж, хэлбэршсэн байна^{1 2}. Монгол Улсад ардын хувьсгал ялсан 1921 оноос өмнөх үеийн шорон гяндан нь хорих ял эдлүүлэх гэхээсээ илүү гэмт этгээдийг ял шийтгэх хүртэл нь түр хугацаагаар хорих буюу өнөөгийн цагдан хорихтой төстэй үйл ажиллагаа явуулдаг байжээ³.

1921 оны долдугаар сард Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн газрын хамтарсан хуралдаанаар төрийн яамдыг шинэчлэн байгуулахад Шүүх Яамны ерөнхий хэлтсийн харьяанд “Гяндан салаа” нэртэй

¹ Б.Алтангэрэл “Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал”, Хууль зүйн докторын зэрэг горилсон дессиртаци, УБ, 2015,10-14 дэх тал

² Судлаач Г.Оюунболд “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэх талаар бусад улс орны туршлага” 2014, УБ, <http://criminalman.blogspot.com>

³ Г.Тамир, “Онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа, онцлог” магистрын дипломын ажил, 2013,УБ,

байгууллага бий болсноор Хорих байгууллагын эх суурь тавигдсан¹ бөгөөд эдүгээ хүртэл хугацаанд тус байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн шинэчлэл 6 удаа хийгджээ. Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хорих ял эдлүүлэх ажиллагааг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх, эрх зүйн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаа энэ цаг үед ихээхэн эрчимжиж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчин түүний дотор хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох, хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх асуудалд анхаарах шаардлага нэгэнт бий болсон нь хорих ял эдлээд суллагдсан этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүйгээр барахгүй өсөх хандлагатай байгаагаар тайлбарлагдана^{1 2}. Эндээс хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүн, хорих ялын үр нөлөө төдийлөн сайнгүй байгааг төвөггүй харж болно. Мөн практик ажилтнуудын хийсэн судалгааны дүнгээс³ үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 8000 байдаг⁴.

2015 оны байдлаар манай улс зуун мянган хүнд ноогдох хоригдлын /262/ тоогоор дэлхийн 216 улсаас 44 дүгээрт бичигдэжээ⁵.

2015 онд дээрх үзүүлэлтээр АНУ 698, Туркменистан 583, Куба 510 хоригдолтойгоор эхний гуравт орсон бол Япон 48, Энэтхэг 33, Нигери 31 хоригдолтойгоор хамгийн сүүлд жагссан байна⁶.

Нэг жишээ дурдахад; сүүлийн олон арван жил дайн тулааны гал тасраагүй, улс төр, нийгмийн хувьд тогтворгүй Афганистан улс зуун мянган хүнд ноогдох ялтны тоогоороо манай улсаас 3 дахин бага байна.

Харьцангуй цөөн хүнтэй боловч хорих ял эдлэгчдийн тоогоороо дэлхийд дээгүүрт бичигдэж, хорих ялын үр нөлөө төдийлөн сайнгүй, хорих

¹ А.Лхагва. Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал. УБ., 2001.9 дэх тал

² Г.Тамир. Онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа, онцлог магистрын дипломын ажил, 2013, УБ, 3 дахь тал. 1988 онд хорих ял эдлэгсдийн 47,2 хувь нь 2 буюу түүнээс дээш удаа ял шийтгүүлэгчид байсан бол 2012 онд энэ тоо 51.6 болж өссөн байна.

³ Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавх хэлтсийн хяналтын прокурор., “Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал”, эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2006 оны №2., 73 дах тал

⁴ Д.Дамдинцэрэн. “Шүүхийн шийлвэр, түүний хэрэгжилт” илтгэл, “Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт” /Үндэсний зөвлөгөөний илтгэлүүд/ 2008, УБ, 162 дахь тал.

⁵ <http://www.prisonstudies.org/country/mongolia>

⁶ Andrew Coyle, Helen Fair, Jessica Jacobson, Roy Walmsley, “Imprisonment Worldwide: The Current Situation and an Alternative Future”, University of London, 2016

газраас суллагдсан этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа зэрэг нь хорих ял эдлүүлэх ажиллагаа эрүүгийн хариуцлагын зорилгыг хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг тодорхойлох энэхүү таагүй үзэгдэл хуучин нийгмийн үеэс өнөөг хүртэл уламжлагдан амь бөхтэй оршсоор байгааг дараах хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлаж байна:

1. Гадаадын туршлагыг алдаатай хэрэгжүүлж, энэ нь өнөөг хүртэл уламжлагдсан: Өнөөгийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэс нь 1966 оны засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулиас улбаатай. Уг хуулийг тухайн үеийн ЗХУ-ын “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” -ийн агуулгыг үндэслэн боловсруулсан байдаг¹. Ингэхдээ “эх хууль” -ийнхаа агуулгыг ихээхэн алдаатай хуулбарласан. Гол алдаа нь юу вэ? гэхээр; ЗХУ-ын хорих байгууллагууд нь жир, чанга, онцгой гэсэн 3 үндсэн дэглэмтэй. тэдгээр дэглэм тус бүр дотроо ердийн, хөнгөтгөсөн, чангатгасан. сахилгажуулсан гэсэн 4 нөхцөлтэй байх ба дэглэм тус бүрд хоригдож буй ялтнууд хоорондоо холилдох ямар ч боломжгүй байхаар зохицуулсан байдаг. Гэтэл манай улсын хуульд жир, чанга, онцгой гэсэн дэглэмийг нь хэрэглэсэн боловч дэглэм тус бүрд байх ёстой ялгаатай 4 нөхцөлийг орхигдуулжээ.

Тухайлбал: жирийн дэглэмтэй хорих ангид анх удаа буюу санамсар болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн этгээд, чанга дэглэмтэй хорих ангид давтан гэмт хэрэгтнүүд, онцгой дэглэмтэй хорих ангид онц аюултай, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээд тус ял эдэлдэг ба дэглэм тус бүрд ял эдлэгсэд суллагдах хүртлээ хоорондоо холилдохгүйгээр ял эдлэх механизмыг бий болгожээ. Жишээ нь: Чанга дэглэмд ял шийтгүүлсэн этгээд хорих ангид ирээд ердийн нөхцөлд хоригдох ба тодорхой хугацаанд засарч хүмүүжиж байгаагаа зан байдлаараа харуулбал хөнгөтгөсөн нөхцөлд шилждэг, эсрэгээрээ засарч хүмүүжих бус, зөрчил дутагдал гаргаж, хорих ангийн дэглэм журмыг зөрчсөн тохиолдолд чангаруулсан нөхцөлд, цаашилбал сахилгажуулах, ганцаарчлан хорих тусгай салбарт 1 жил хүртэл хугацаагаар ял эдлэх ба энэ нь манай дэглэм чангатгах, бууруулах эрх зүйн зохицуулалттай төстэй. Гэхдээ жир, чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтнууд хоорондоо холилдох боломжгүй ажээ. Энэ нь хорих ялыг ялгамжтай эдлүүлэх суурь зарчимтай нийцэх ба манай улсын хувьд энэхүү зарчим хэрэгжих боломжгүй байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн

¹ А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. 2008. - УБ, 117 дахь тал.

ялтанд шүүхээс хорих ял оногдуулахдаа ял эдлэх дэглэмийг тогтоох боловч ял эдлэх явцад нь дэглэм бууруулах, дээшлүүлэх эрх зүйн зохицуулалтын механизмыг хэрэглэснээр уг суурь зарчмыг зөрчигдөхөд хүргэдэг. Энэхүү зохицуулалт нь ялтны хүмүүжлийг дэмжих зорилготой боловч зан төлөвийн доголдолтой этгээдийг дэглэм чангаруулах, хөнгөтгөх замаар хорих анги өөрөөсөө зайлуулах, ёс суртахууны доголдол, гэмт зан үйлийг халдварыг тараах, ял эдлэгчдийг хооронд нь холих механизм болдог.

2. Ялыг ялгамжтай эдлүүлэх тухай суурь зарчим алдагдсанаас хорих ялын үр нөлөө буурсан:

Хорих ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд ял эдлэх ахуй, орчин, нөхцөлийг сайжруулах, олон улсын эрх зүйн зохицуулалтын аргыг өөрийн орны хөрсөнд буулгах тухай асуудлаар хязгаарлаж болохгүй.

Хорих ялын үр нөлөө нийгмийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаа дээр дурдсан. Өөрөөр хэлбэл шоронд ял эдэлсэн хүмүүс засарч хүмүүжих бус харин ч шоронжоод, гэмт хэрэг үйлдэх арга, барилд суралцаад, шоронгийн амьдралд дасан зохицоод гардаг гэж хэлэхэд нэг их хилсдэхгүй биз ээ. Иймд уг асуудлыг шинжлэх ухаанчаар шинжлэн судалж, оношлох. учир шалтгаан, зүй тогтлыг илрүүлэх нь чухал зангилаа асуудлын нэг болоод байна. Уг асуудлын мөн чанарыг ял эдэлж буй бие хүн буюу ялтантай холбон тайлбарлахыг эрмэлзсэн болно. Учир хүн бүр дахин давтагдашгүй өвөрмөц шинжүүдтэй. Нас, хүйс, боловсрол, мэргэжил, шашин шүтлэг, үйлдсэн гэмт хэрэг, анх давтан. ялын хугацаа, зан байдал, засрал хүмүүжлийн төвшин гэх мэт. Иймд ял эдлэгчдийг нийтлэг шинжүүдээр нь тодорхой төрөлд ангилж, хооронд нь холилдохгүйгээр ял эдлүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай.

Хүний төлөвшил, нийгэмшил, зан байдал нь хүмүүний харилцаа, хамтын ажиллагааны явцад бүрэлддэг зүй тогтолтой. Хорих анги дахь удаан хугацааны хамтын аж амьдралын явцад хүмүүс бие биеийнхээ төлөвшил, зан байдал, нийгэмшил, ёс суртахуунд нөлөөлөх нь гарцаагүй бөгөөд энэ нөлөөлөл нь ихэвчлэн сөрөг хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл хорих байгууллагад явуулж буй сургалт, хүмүүжлийн ажлын нөлөөллийн үр дүнгээс ялтнуудын бие биедээ үзүүлэх сөрөг нөлөөллийн үр дүн илүү байдаг. Энэ байдал ялыг ялгамжтай эдлүүлэх зарчим алдагдах тусам нэмэгддэг.

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтаас, засарч хүмүүжиж буй ялтныг засрал хүмүүжлээ олоогүй ялтаас

тусад ял эдлүүлэх тухай¹ хуулийн заалт байгаа боловч өнөөгийн хорих байгууллагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтаас хамаарч хэрэгжүүлэх боломжгүй байна.

3. Хорих ял эдлүүлэх дэглэмийг чангатгах, хөнгөтгөх тухай эрх зүйн зохицуулалт нь хорих ялыг ялгамжтай эдлүүлэх зарчимд сөргөөр нөлөөлж байна:

Дэглэм чангаруулах, бууруулах тухай эрх зүйн зохицуулалт нь ялтны зан төлөвт гарсан нааштай өөрчлөлт, засрал хүмүүжлийг дэмжих зорилготой. Гэтэл хугацаа болсон л бол дэглэм бууруулах ёстой мэт хандаж, уг зохицуулалтыг хавтгайруулан хэрэглэснээс дэглэм буурсан ялтан зөрчил гаргах, эргээд дэглэмийг чангаруулахад хүргэдэг практик жишээ маш олон байна. Энэ нь дэглэм бууруулахдаа засарч хүмүүжсэн эсэхийг голлон анхаарах бус хугацаа болсон эсэхийг голлох болсонтой холбоотой. Засрал хүмүүжлээ олоогүй, хувийн зан чанарын хувьд доголдолтой, давтан гэмт хэрэгтнүүдийг жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэхээр дэглэм бууруулах нь ихээхэн сөрөг үр дагавартай.

Мөн шалихгүй зөрчил гаргасан ялтныг дэглэм чангаруулах нь тухайн ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэхгүй. Харин ч түүний зан төлөвийг эвдэж, хувь хүнийх нь хувьд хорлож буй хэрэг мөн. Ялтныг дэглэм чангаруулснаараа тухайн хорих анги ялтныг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаагаа харуулсан хэрэг. Иймд ялтныг аль болох дэглэм чангаруулахгүй байх бодлого баримтлах учиртай. Нөгөө талаас зөрчил гаргасан ялтаныг өөрөөсөө зайлуулах хэрэгсэл болгон ашигладаг нь нууц биш юм.

Одоогийн нөхцөлд шүүхээс анх таслан шийдвэрлэхдээ тухайн ялтанд тогтоосон дэглэмийн төрлийг суллагдах хүртэл нь аль болох өөрчлөхгүй байх бодлого баримтлах хэрэгтэй.

Эрүүгийн^{1 2} болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг судлан үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагааг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэхдээ хорих ялын үр нөлөөг бууруулж буй дээрх хүчин зүйлсийг харгалзаагүй болох нь харагдаж байна. Энэхүү өөрчлөлт нь асуудлыг голыг оноогүй, нэр томьёоллын шинжтэй, өнгөц, хэлбэр төдий хийгдсэн бөгөөд 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн агуулгыг хэвээр хадгалжээ гэсэн дүгнэлт хийхэд хүргэлээ.

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118-р зүйл.

² <http://www.legalinfo.mn/law/details/11634>

Мөн эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд¹ ялтныг үйлдсэн гэмт хэрэг, хувийн байдлыг нь харгалзан ангилан төрөлжүүлэх өөрөөр хэлбэл хорих ял эдлүүлэх дэглэмийг ямар үндэслэлээр тогтоох тухай өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн хэм хэмжээг^{1 2} байхгүй болгосон нь шүүхийн эрх мэдлийг хэт өргөжүүлж, өмнөхөөсөө ухралт хийжээ.

Өнөөгийн хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэс суурь нь 1966 онд батлагдсан засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль бөгөөд уг хуулийг боловсруулахдаа тухайн үеийн ЗХУ-ын "засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль" эх загвараа болгожээ. Ингэхдээ ялыг ялгамжтай эдлүүлэх тухай ЗХУ-ын "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль"-ийн суурь зарчмыг алдагдуулсан ба дараа дараагийн хууль тогтоомжид энэ хэвээр уламжлагдан иржээ.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэх тухай төрийн бодлого Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хэлбэршихдээ хэлбэрдсэн, нэр томьёоны өөрчлөлт төдийхнөөр тусгагджээ.

Хуулийн төсөлд хорих ялыг ялгамжтай эдлүүлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дорвитой өөрчлөлт хийгдээгүй, төсөл энэ хэвээр батлагдвал цаашид хорих ялын үр нөлөө өмнөхөөсөө төдийлөн сайжрахгүй.

1. Хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн боловсруулахдаа ялыг ялгамжтай эдлүүлэх суурь зарчмыг баримтлах

2. Хорих ялын үр нөлөөг бууруулж буй хүчин зүйл, шалтгаан. зүй тогтолыг илрүүлэх, хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн онолын суурь судалгаа хийх

3. Рецидив, онц аюултай гэмт хэрэгтнүүдээс бусад ялтнуудыг тусгаарлах, хоорондоо холилдохгүйгээр ял эдлэх эрх зүйн зохицуулалтын механизмийг бий болгох

¹ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5-р зүйлийн 5,6 дахь заалт

² 2002 оны “Эрүүгийн хууль” 52-р зүйл